



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.10, 30 дугаар зүйлийн 30.2, 30.3, 20 дугаар зүйлийн 20.1, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 286 дугаар тушаалаар батлагдсан "Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Нийтийг хамарсан гэнэтийн гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний журам"-ыг нэгдүгээр, "Нийтийг хамарсан гэнэтийн гамшгийн үед шуурхай удирдлага, зохион байгуулалтад шилжин ажиллахад ашиглах эрх зүйн баримт бичгийн жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.ЧУЯТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн  
А/03 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## НИЙТИЙГ ХАМАРСАН ГЭНЭТИЙН ГАМШГИЙН ҮЕД АЖИЛЛАХ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийтийг хамарсан гэнэтийн гамшиг үүссэн үед ажиллах нийслэлийн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, Онцгой комисс, Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн анги, Сайн дурын хэсэг, Хуулийн этгээд /цаашид нийслэлийн хүч хэрэгсэл гэх/-ийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Нийтийг хамарсан гэнэтийн томоохон гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хүч хэрэгслийг татан оролцуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хуваарилах, сэлгэн ажиллуулах, дадлага, сургуулийг зохион байгуулах, ажилтан, алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Энэхүү журам нь зөвхөн нийслэлийн нутаг дэвсгэрт үйлчилж, нийслэлийн төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдэд хамаарна.

### Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. "Нийтийг хамарсан гамшиг" гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

2.2. "Шуурхай штаб" гэж гамшиг ослын үед үүрэг гүйцэтгэн оролцогч байгууллагуудыг удирдлагаар хангаж, харилцан ажиллагааг зохион байгуулах бүрэлдэхүүнийг;

2.3. "Шуурхай штабын удирдагч" гэж Нийслэлийн Онцгой комиссоос томилогдсон эрх бүхий албан тушаалтан, Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн Онцгой байдлын газрын удирдах албан тушаалтан буюу мэргэшсэн албан хаагчийг;

2.4. "Голомтын бүс" гэж гамшиг, аюулт үзэгдэл болон ослын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг;

2.5. "Төрийн цэргийн байгуулал" Тайван цагт Зэвсэгт хүчин, Хилийн болон Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ.

2.6. "Шуурхай удирдлагын байр" гэж эрэн хайх, аврах ажиллагааг хөдөлгөөнт болон суурин хэлбэрээр удирдаж буй ажлын байрлалыг;

### Гурав. Удирдлагын зарчим

3.1. Хуульд нийцсэн байх;

3.2. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах;

- 3.3. Хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдал хангагдсан байх;
- 3.4. Тогтвортой, тасралтгүй удирдлагатай байх;
- 3.5. Гэнэтийн гамшгийн голомтод шуурхай шилжин байрлаж хор уршгийг богино хугацаанд арилгах;
- 3.6. Гамшгийн хор уршгийг хохирол багатайгаар даван туулах;
- 3.7. Харилцан ажиллагааг тасралтгүй зохион байгуулах;

#### Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

- 4.1. Гэнэтийн томоохон гамшгийн үед ажиллах "Шуурхай штаб"-ын бүрэлдэхүүнийг нийслэлийн Засаг даргын захирамжаар томилгоожуулна.
- 4.2. Шуурхай штабын удирдагч нь нийслэлийн Онцгой комиссын гишүүн, орлогч нь тухайн чиглэл хариуцсан байгууллагын орлогч дарга байна.
- 4.3. Шуурхай штабын удирдагч нь голомтын бүсэд тухайн чиглэлийн байгууллагын ажилтны заавар, зөвлөгөөг үндэслэн эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулна.
- 4.4. Шуурхай штабын байрыг хөдөлгөөнт болон суурин хэлбэрээр Онцгой комиссын даргын шийдвэрээр тухайн чиглэлийн байгууллага тус бүр тохижуулах ажлыг зохион байгуулж, бэлэн байдлыг хангасан байна.
- 4.5. Шуурхай штаб нь нийт оролцогч байгууллагуудыг удирдлагаар хангаж, харилцан ажиллагааг зохион байгуулна.
- 4.6. Шуурхай штабын удирдагчийн шийдвэрээр шаардлагатай тохиолдолд дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.
- 4.7. Нийтийг хамарсан гэнэтийн гамшгийн нөхцөл байдал, цар хүрээ, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Шуурхай штабын удирдагчийн шийдвэрээр нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн хүч хэрэгслийг хуулийн хүрээнд татан оролцуулж болно.
- 4.8. Гамшгийн голомтод ажиллах нийслэлийн хүч хэрэгсэл нь 3 хоногийн хүнс, хээрийн үүргэвч, шаардлагатай техник, багаж хэрэгслийг бэлтгэн ирж үүрэг гүйцэтгэнэ.
- 4.9. Нийслэлийн хүч хэрэгсэл нь нэгдсэн радио холбоонд орно.
- 4.10. Оролцогч байгууллагуудын томилгоот бүрэлдэхүүний хоол хүнс 3 хоногоос хэтэрсэн тохиолдолд нийслэлийн Засаг даргын Тамгын газар, томилгоот гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд хоол хүнсний хангалтыг зохион байгуулна.
- 4.11. Нэгдсэн дадлага, сургуулийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, иргэн, хуулийн этгээдийн хүч хэрэгслийг оролцуулан нийслэл, дүүргийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан зохион байгуулна.
- 4.12. Нийтийг хамарсан гэнэтийн гамшиг тохиолдсон үед төрийн цэргийн байгууллагууд холбогдох батлагдсан төлөвлөгөө, хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргийг гүйцэтгэж оролцоно.
- 4.13. Сайн дурын хэсэг, Улаан загалмайн байгууллага нь хууль тогтоомжид заагдсан үүргийн дагуу оролцож болно.

#### Тав. Шуурхай штабын удирдагчийн эрх, үүрэг

- 5.1. Шуурхай штабын удирдагчийн эрх:

5.1.1. Нийтийг хамарсан гэнэтийн гамшгийн үед, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд нийслэлийн хүч хэрэгслийг татан оролцуулах;

5.1.2. Нийслэлийн хүч хэрэгслийг уялдуулан зохицуулах үүрэг бүхий "Шуурхай штаб"-ын ажиллах журмыг нийслэлийн Засаг даргын захирамжаар батална.

5.1.3. Үүрэг, даалгавар биелүүлээгүй ажилтан, албан хаагчид хариуцлага тооцуулах саналав эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлэх;

5.2 Шуурхай штабын удирдагчийн үүрэг:

5.2.1 Монгол Улсын Засгийн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн удирдлага, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх;

5.2.2 Нийтийг хамарсан гэнэтийн гамшгийн үед нийслэлийн хүч хэрэгслийг удирдан зохион байгуулах, харилцан ажиллагааг хангах;

5.2.3 Үүссэн нөхцөл байдлыг үнэлж, мэргэжлийн байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргах;

5.2.4 Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх саналыг тухайн шатны Засаг даргад уламжилж, шийдвэр гаргуулах;

5.2.5 Дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

#### Зургаа. Үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүний эрх, үүрэг

6.1. Үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүн нь дараах эрхтэй:

6.1.1. Ажилтан, албан хаагч нь дулаан байр, халуун хоол хүнс, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангагдах;

6.1.2. Ээлжээр амрах;

6.1.3. Эрүүл мэндээ хамгаалуулах;

6.2. Үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүн нь дараах үүрэгтэй:

6.2.1. Ажилтан, албан хаагч төрийн алба хаагчийн ёс зүйг эрхэмлэн дээдэлж, сахилга бат, дэг журмыг сахих;

6.2.2. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

6.2.3. Шуурхай штабын удирдлагад захирагдах;

6.2.4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх, эргэж танилцуулах;

6.2.5. Тавигдсан үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай техник, багаж хэрэгслийг бэлтгэж, бэлэн байдлыг хангаж ажиллах;

#### Долоо. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн хэрэгжилт

7.1 Нийтийг хамарсан гамшгийн үед ажиллах бүрэлдэхүүн нь "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийг мөрдлөг болгон ажиллана.

## Найм. Санхүүжилт

8.1 Нийтийг хамарсан гэнэтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэнэ.

8.2. Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс давсан хохирол учирсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу гамшгийн хохирлыг даван туулахад шаардлагатай төсвийг Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлнэ.

8.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.1 дэх хэсэгт заасны дагуу санхүүжилтийг жил бүрийн төсөвтөө тусгана.

8.4. Иргэн, хуулийн этгээдээс гарсан зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 133 дугаар тогтоолын дагуу шийдвэрлүүлнэ.

## Ес. Бусад

9.1. Нийтийг хамарсан гамшгийн үед ажилласан нөхцөл байдлын мэдээг тухай бүрд, нэгдсэн дүн мэдээний танилцуулгыг гамшгийн нөхцөл байдал дуусснаас хойш ажлын 7 хоногт багтаан нийслэлийн Онцгой комиссын даргад танилцуулна.

9.2. Хил залгаа нутаг дэвсгэрт гамшгийн нөхцөл үүссэн үед гамшгаас хамгаалах хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлж ажиллана.

9.3. Нийтийг хамарсан гамшгийн үед албан үүргээ хангалтгүй биелүүлсэн байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтанд Төрийн албаны тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн  
А/03 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нийтийг хамарсан гэнэтийн гамшгийн үед шуурхай удирдлага, зохион  
байгуулалтад шилжин ажиллахад ашиглах  
эрх зүйн баримт бичгийн жагсаалт

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учирсан, онцгой нөхцөл байдал үүсэж болзошгүй үед шуурхай удирдлага, зохион байгуулалтыг дараах хууль тогтоомж болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохион байгуулна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах тухай хууль,
- Галын аюулгүй байдлын тухай хууль,
- Улсын нөөцийн тухай хууль,
- "Онцгой нөхцөл байдал үүссэн үед Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Тагнуул, Цагдаа, Шүүхийн шийдвэр, Онцгой байдлын байгууллагуудын харилцан ажиллах журам" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны мн/03 дугаар зарлиг,
- Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох төлөвлөгөө /Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоол/,
- "Онцгой нөхцөл байдал үүссэн үед Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Тагнуул, Цагдаа, Шүүхийн шийдвэр, Онцгой байдлын байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах ерөнхий төлөвлөгөө /Засгийн газрын 2015 оны мн/491 дүгээр тогтоол/,
- Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх журам /Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол/,
- Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах журам, Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам /Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоол/,
- Хоолны зардлын дундаж норматив /Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоол/,
- "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх, систем хоорондын харилцан ажиллагааг зохицуулах журам" Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал, Цаг уур орчны шинжилгээний газрын дарга нарын хамтран баталсан 2016 оны А/205, А/72, А/65 дугаар тушаал,
- Улсын албадын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө,
- Нийслэл, 21 аймгийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө,
- Онцгой нөхцөл байдал үүссэн үед Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын харилцан ажиллах чиглэлийн төлөвлөгөө 2016 оны мн/161,
- Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаал "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулах тухай" журам